



ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМ
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2016 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/37

Улаанбаатар хот

Бүтэц, дүрэм чиг үүрэг батлах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 12 дүгээр сарын 18 ны 495 тоот тушаал, 497 тоот тушаалыг үндэслэн ТУШААХ НЬ:


1. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Сувилахуйн албаны бүтцийг нэгдүгээр хавсралтаар, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Сувилахуйн албаны үлгэрчилсэн дүрмийг хоёрдугаар хавсралтаар, Сувилахуйн тусламж үйлчилгээнд үйл ажиллагааны 5 шатлалыг хэрэгжүүлэх журмыг гуравдугаар хавсралтаар, Шаардлагатай үйлчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх зааварыг дөрөвдүгээр хавсралтаар, Сувилахуйн тусламж үйлчилгээнд нэмэлтээр хэрэглэх зарим онош, тодорхойлолтыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шинэчлэн зохион байгуулсан бүтэц, журам, зааврыг мөрдөн ажиллахыг Сувилахуйн албаны дарга /О.Оюунтөгс /-д даалгасугай.

3. Энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн хөгжлийн албаны ахлах мэргэжилтэн /С.Ариунболд/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан СЭМҮТ-ийн Ерөнхий захирлын 2013 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 92 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л.НАСАНЦЭНГЭЛ

000046

**Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн
Сувилахуйн албаны бүтэц**

Сувилахуйн албыг дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

1. Сувилахуйн албаны дарга - О.Оюунтөгс
2. Сувилахуйн гардан үйлдлийн стандарт, асаргаа, сувилгаа хариуцсан арга зүйч – П.Бямбасүрэн
3. Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний хөгжил, сургалт, судалгаа шинжилгээ хариуцсан арга зүйч – Ж.Цэцэгмаа

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Сувилахуйн албаны үлгэрчилсэн дүрэм

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Сувилахуйн алба нь /цаашид алба гэнэ/ байгууллагын үндсэн зорилго, зорилттой уялдуулан сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж, үйлчилгээний асуудлыг байгууллагын түвшинд шийдвэрлэн хэрэгжүүлэх үүрэг бүхий орон тооны бүтэц байна.
2. Албаны зорилго нь сувилахуйн болон эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээг удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн хөгжлийг хангах, тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд оршино.
3. Албыг сувилагч, эмнэлгийн бусад тусгай мэргэжилтнүүдийн төлөөллийг хангасан 2-5 хүний бүрэлдхүүнтэйгээр байгууллагын даргын тушаалаар батлан, үйл ажиллагааны болон цалин, урамшууллын зардлыг жил бүр байгууллагын төсөвт тусган ажиллана.
4. Албаны дарга нь сувилахуйн боловсролын бакалаврын болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлийн болон боловсролын бусад зэрэг, цол бүхий сувилагч мэргэжилтэн байх бөгөөд тухайн байгууллагын Удирдлагын зөвлөлийн албан ёсны гишүүн байна.
5. Алба нь үйл ажиллагаа явуулах зориулалтын өрөө тасалгаагаар хангагдана.

Хоёр. Албаны бүрэлдэхүүн

1. Эрүүл мэндийн байгууллагын тасаг, нэгжид орон тооны ахлах сувилагч ажиллана.
2. Албанд ажиллах арга зүйч сувилагчийн тоо нь эрүүл мэндийн байгууллагын сувилагч эмнэлгийн тусгай мэргэжилтний тооноос хамаарна. Үүнд:
 - 2.1 50-150 бол -1-2
 - 2.2 150-300 бол -3-4
 - 2.3 300 дээш бол 5 хүртэл арга зүйч сувилагчийг ажиллуулж болно.

Гурав. Албаны үүрэг

1. Удирдлага манлайлалын үүрэг

- 1.1 Албаны гишүүдийн ажил үүргийн хуваарийг батлах, хяналт тавих

- 1.2 Байгууллагаас зохион байгуулж буй арга хэмжээ, шинээр гарсан тушаал, шийдвэр, эрх зүйн баримт бичгийг хэрэгжүүлэх, шийдвэрийг хамт олонд мэдээлэх, хэрэгжүүлэх арга хэмжээг авах
- 1.3 Тусламж үйлчилгээний эрх зүйн, орчны үнэлгээг хийж, шаардлагатай асуудлаар заавар, журам, стандарт оруулах
- 1.4 Тусламж үйлчилгээний одоогийн байдал, ойрын болон хэтийн төлөв, стратегийн зорилго, зорилтыг тодорхойлох зорилгоор 2-4 жил тутам үйл ажиллагааныхаа гүйцэтгэлийг үнэлэх арга хэмжээг / Хурал, чуулган / зохион байгуулж байх
- 1.5 Сувилахуйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх стратегийн хэрэгжилтийг хангаж ажиллах
- 1.6 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлж ажиллах арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжүүлэлтийг хангаж ажиллах
- 1.7 Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний хөдөлмөрийн гэрээний үнэлгээнд оролцох, урамшуулах
- 1.8 Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний цалин, урамшуулал, нийгмийн халамжийн талаарх асуудлыг төлөвлөх, зохицуулах
- 1.9 Холбогдох тушаал зааварт заасан мэдээ тайлан, удирдах дээд байгууллагаас өгсөн чиг үүргийн хэрэгжилтийг цаг хугацаанд нь хүргүүлэх
- 1.10 Сувилагч мэргэжилтнүүдийн ажлын ачааллыг хөнгөвчлөх олон талт ажиллагаа зохион байгуулах
- 1.11 Сувилагчийн постуудыг дотоод сүлжээ бүхий компьютер суурьтай программ, хангамжтай болгох асуудлыг судалж шийдвэрлүүлэх
- 1.12 Мэргэжилтнүүдийн компьютер, сүлжээнд ажиллах, олон улсын мэдээ мэдээллийг авч ажиллах ур чадварыг нэмэгдүүлэх

2. Тусламж, үйлчилгээний чанар сайжруулалт

- 2.1 Чанар сайжруулах ажлын төлөвлөгөөг гарган баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах
- 2.2 Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг мэргэжлийн болон ёс зүйн алдаа дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- 2.3 Үйлчлүүлэгчийн болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг хангасан орчин, нөхцөл бүрдүүлэх үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх
- 2.4 Байгууллагын хэмжээнд сувилахуйн тусламж үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах, шалган зааварлах, гүйцэтгэлд хяналт тавих

- 2.5 Халдвар хамгааллын дэглэм, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимын хэрэгжилтэд хяналт тавих, чанарыг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулан арга хэмжээ авч ажиллах
- 2.6 Тусламж үйлчилгээнд хяналтын хуудас нэвтрүүлж, хяналт тавьж ажиллах
- 2.7 Сувилахуйн тусламж үйлчилгээнд “Сувилгааны түүх” –ийн бичилт, түүний чанарыг тогтмол сайжруулж ажиллах
- 2.8 Сувилагч үйлчлүүлэгчийн биеийн байдалд үнэлгээ өгөх сургалтыг тасралтгүй зохион байгуулж, бүх сувилагчдыг хамруулж, ур чадварыг нэмэгдүүлэх

3. Нотолгоонд суурилсан тусламж үйлчилгээг хөгжүүлэх

- 3.1 Судалгааны арга барил эзэмшүүлэх сургалт тогтмол зохион байгуулах
- 3.2 Байгууллагын тусламж, үйлчилгээний өвөрмөц чиглэлээр нотолгоо шаардлагатай сэдэв, судалгааны чиглэл зарлаж судалгааны ажилд мэргэжилтнүүдийг өргөнөөр оролцуулах
- 3.3 Судалгааны ажлын үр дүнг тусламж, үйлчилгээнд нэвтрүүлэх шинэ туршлага нэвтрүүлэх ажилд хамт олныг уриалах, манлайлан ажиллах

4. Мэргэжилтнийг хөгжүүлэх төлөвлөгөө

- 4.1 Шинэ төгсөж ирсэн мэргэжилтнийг сурган, дадлагажуулах
- 4.2 Олон жил ажилласан туршлагатай зөвлөх багийг томилох сургалт, зөвлөгөө өгөх ур чадварыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжих, өргөжүүлэх
- 4.3 Олон улс болон бусад ЭМБ-уудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээ авах

5. Хүний нөөцийн бодлого төлөвлөлт, сургалт

- 5.1 Мэргэжилтнүүдийн хүний нөөцийн бүрдэлт, хөгжлийг хангах асуудлаарх үйл ажиллагааг байгууллагын түвшинд хариуцах хамтран ажиллах
- 5.2 Тусламж үйлчилгээний ачааллын судалгааг тогтмол хийж, хэрэгцээтэй орон тоог нэмэгдүүлэх, ноогдох зардлыг төсөвт суулгах арга хэмжээнд санал дүгнэлт өгөх
- 5.3 Сувилагч, тусгай мэргэжилнүүдийн зөвлөгөө өгөх, сургах, НЭМ, эрүүл ахуй, урьдчилан сэргийлэх ажлын талаар мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлж ажиллах
- 5.4 Мэргэжилтнүүдийг гадаад хэлний мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтад хамруулах, гадаад дотоодод сургаж мэргэшүүлэх үйл ажиллагааг төлөвлөх

5.5 Сувилагч эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг мэргэжлийн зэрэг горилох, ахиулахад бэлтгэх

Дөрөв. Сувилахуйн албаны үйл ажиллагааны хяналт, үнэлгээ

1. Алба нь үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрийн хяналт, биелэлтийг хамт олноор хэлэлцүүлэн үнэлгээ, дүгнэлт гаргуулан ажиллана.
2. Алба нь үйл ажиллагааны тайланг улирал бүр албаны хурлаараа хэлэлцүүлэн байгууллагын захиргааны зөвлөлийн хуралд тайлагнана.
3. Албаны жилийн эцсийн тайланг төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тайлагнана.
4. Албаны үйл ажиллагааны гол үзүүлэлт нь үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн хувь болно.

СЭМҮТ-ийн Ерөнхий захирлын
2016 оны сарын ...-ны өдрийн
.... дугаар тушаалын ... дугаар хавсралт

**Сувилахуйн тусламж үйлчилгээнд үйл ажиллагааны
5 шатлалыг хэрэгжүүлэх журам**

Нэг. Ерөнхий зүйл.

1. Сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, сувилагчийн мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэхэд энэхүү журмын үндсэн зорилго оршино.

2. Эрүүл мэндийн сайдын 2013 оны 450 дугаар тушаалаар батлагдсан сувилахуйн тусламж үйлчилгээний анхан шатны маягтуудыг сувилагч хөтлөн явуулахтай холбогдуулан энэхүү журмыг нэмэлтээр ашиглана.
3. Сувилахуйн тусламж үйлчилгээг үнэлэх, оношлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, дүгнэх 8 шатлалаар үзүүлнэ.
4. Сувилахуйн тусламж үйлчилгээнд сувилагчийн хөтлөж буй анхан шатны маягтууд нь хариуцлага хяналтын нэгдсэн шаардлага сувилагчийн ажлын чанарын үзүүлэлт болно.

Хоёр. Сувилахуйн тусламж үйлчилгээний анхан шатны маягыг хөтлөхөд сувилагчид тавигдах дараах нийтлэг шаардлагатай байна.

2.1 Нийтлэг шаардлага:

1. Ээлж авч байгаа сувилагч нь ээлж хүлээлгэн өгч байгаа сувилагчийн хийсэн асаргаа сувилгааны тэмдэглэлтэй нарийвчлан танилцаж, анхаарах шаардлагатай асуудлыг тодруулж, нэмэлтээр хийх буюу орхигдсон ажилбар байгаа эсэхийг нягталж сувилахуйн тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажиллана.
2. Сувилагч нь үзүүлсэн асаргаа сувилгааны үйлдэл бүрийг сувилгааны түүхэнд цаг алдалгүй бичиж тэмдэглэх ба нөхөн тэмдэглэл хийхээс зайлсхийнэ.
3. Үйлчлүүлэгчээс цуглуулсан тэмдэглэл, бодит үзлэг, үнэлгээ, асаргаа сувилгаа, сувилгааны төлөвлөгөө, гүйцэтгэл, үр дүнг товч тодорхой байдлаар хар, хөх өнгийн бал ашиглан тод, гаргацтай бичнэ.
4. Сувилгаа хийсэн сувилагч гарын үсгээ татлахгүй бүтэн нэрээр, он, сар, өдөр, цагийн нарийвчлалын хамт бичиж тэмдэглэж хэвшсэн байна.

2.2 Хориглох зүйлс:

1. Хийхээр төлөвлөж буй эмчилгээ, сувилгааг урьдчилан тэмдэглэхийг хориглоно.
2. Тухайн сувилагч өөрөө биечлэн тухайн тусламжийг үзүүлээгүй атал бусдын өмнөөс тэмдэглэгээ хийхийг хориглоно.
3. Хийсэн асаргаа сувилгаатай хамааралгүй зүйлсийг бичиж тэмдэглэхийг хориглоно.
4. Алдаатай бичсэн гэж үзсэн зүйлээ баллах, арилгагч хэрэглэхийг хатуу хориглох ба алдаатай бичсэн хэсгийн доогуур зурж тэмдэглэн, залруулгыг нь бичнэ.

5. Амархан арилгах бал, харандаагаар бичиж тэмдэглэхийг хориглоно.
6. Тэмдэглэлийн дунд хоосон зай мөр орхихыг хориглоно.

Гурав. Сувилахуйн үйл ажиллагааны 5 шатлал

1. Сувилагч сувилахуйн тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ үнэлэх, оношлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, дүгнэх гэсэн 5 шатлал /И.Ж. Орландо 1958 он/-ыг баримтлана.
2. Сувилахуйн тусламж, үйлчилгээний 5 шатлалт үйл ажиллагаа нь асуудлыг илрүүлэх, шийдвэрлэх хоорондоо уйлдаа холбоо бүхий тусламж, үйлчилгээний чанар, тасралтгүй байдлыг хангах зорилгоор хийгдэх бөгөөд сувилагч энэхүү хийсэн үйл ажиллагааг тусгай батлагдсан маягад бичиж тэмдэглэнэ.

3.1 ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН БИЕИЙН БАЙДАЛД ҮНЭЛГЭЭ ӨГӨХ /АЖИЛЛАГААНЫ НЭГДҮГЭЭР ШАТ/

1. Сувилагч үйлчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх гэдэг нь үйлчлүүлэгчийн өвчин, шаналгаа зовиурыг илрүүлэх зорилгоор ажиглах, асуух, бодит үзлэг хийж мэдээлэл, цуглуулах, цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх, мэдээллийг тэмдэглэх сувилагчийн сэтгэн бодох шийдвэр гаргах ур чадварт суурилсан үйл ажиллагаа болно.
2. Үйлчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэхдээ олон улсын сувилахуйн тусламж үйлчилгээнд нийтлэг хэрэглэж байгаа, сувилахуйн шинжлэх ухааны суурь онол, Маржори Гордоны тодорхойлсон үйл ажиллагааны хэв шинжээр үнэлнэ. /Эрүүл мэндийн сайдын 2013 оны 450 тоот тушаал/

3.2 СУВИЛАХУЙН ОНОШ ТАВИХ /ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХОЁРДУГААР ШАТ/

1. Сувилахуйн онош гэдэг нь үйлчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлсэний дүнд дүгнэлт хийх шийдвэр гаргах буюу сувилагчийн хийсэн үнэлгээнд үндэслэн үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдалд хийсэн дүгнэлт болно.
2. Сувилгааны онош нь үйлчлүүлэгчид тулгарч буй эрүүл мэндийн асуудал зовиурыг шийдвэрлэхэд чиглэсэн, үйлчлүүлэгч, сувилагч хоёрын хэлэлцэж, зөвшилцсөн хамтын шийдвэр байна.
3. Сувилахуйн асуудал буюу оношийг тавихдаа “Эмчлүүлэгчийн биеийн байдалд сувилагч үнэлгээ өгөх” маягт /ЭМС-ын 450 дугаар тушаал/-д

заасан оношийг баримтлахаас гадна энэхүү тушаалын гуравдугаар хавсралтад заасан оношийг нэмэлтээр ашиглана.

4. Сувилахуйн онош нь үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдалд үүссэн асуудалд суурилсан, шалтгаан заасан шинж тэмдэгүүд байна.

3.3 ТӨЛӨВЛӨХ БОЛОВСРУУЛАХ /ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГУРАВДУГААР ШАТ/

1. Сувилахуйн төлөвлөгөө нь асуудлыг шийдвэрлэхийн тулд үзүүлэх асаргаа сувилгааг хэрхэн, ямар хугацаанд ямар давтамжтайгаар, хэрхэн хийж хэрэгжүүлэх, шийдвэрлэх арга зам, гарцыг үйлчлүүлэгчтэй зөвшилцсөний үндсэн дээр үнэн бодитой байдлаар тодорхойлон бичсэн сувилагчийн тэмдэглэл юм.
2. Сувилахуйн төлөвлөгөөг үйлчлүүлэгчийн эрүүл мэндэд тулгарсан асуудалд зовиур шаналгааг хамтран шийдвэрлэх гол зарчмыг баримтлан нэн яаралтай чухлаас нь эхлэн ач холбогдлоор нь дугаарлан төлөвлөнө.
3. Төлөвлөгөөг сувилахуйн үйл ажиллагааны хэрэгжүүлэлтийн болон эрүүл мэндийн боловсрол олгох гэсэн чиглэлээр ангилан төлөвлөж болно.

3.4 ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ /ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДӨРӨВДҮГЭЭР ШАТ/

1. Сувилахуйн хэрэгжүүлэх үе шат нь төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр сувилагчийн гүйцэтгэсэн ажилбар, үйл ажиллагааны биелэлт болно.
2. Төлөвлөгөөг өөрчлөх шаардлагатай бол тухай бүрт бичиж тэмдэглэсний үндсэн дээр төлөвлөлтийг сайжруулан, шинээр төлөвлөж байна.

3.5 ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДҮГНЭЛТ ХИЙН, АХИН ТӨЛӨВЛӨХ /ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАВДУГААР ШАТ/

1. Энэхүү үе шат нь тавьсан зорилт, төлөвлөлт хэрхэн биелж, үйлчлүүлэгчийн биед ямар ахиц гарсан, дахин төлөвлөх шаардлагатай эсэх талаар хийсэн сувилагчийн шийдвэр гаргаж, дүгнэлт хийснийг бичиж тэмдэглэсэн баримт бичиг болно.
2. Тавдугаар шатлалын зорилго нь сувилагчийн хийсэн сувилахуйн тусламж, үйлчилгээ нь үйлчлүүлэгчид эерэг нөлөө үзүүлсэн эсэх, зөв сувилгаа хийгдсэн эсэхийг үнэлэх зорилготой.
3. Сувилагч төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллаж байх явцад үйлчлүүлэгчийн биед гарсан өөрчлөлт, үзүүлсэн тусламжийн дүнд

гарсан эерэг болон сөрөг үр дагавруудыг байнга хянаж бичиж тэмдэглэнэ.

Дөрөв. Хяналт үнэлгээ.

1. Энэхүү эрүүл мэндийн байгууллагуудын сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар сувилагчдын ур чадварыг үнэлэхэд энэхүү журмыг баримтлаж болно.
2. Эрүүл мэндийн байгууллагуудын сувилахуйн албад сувилахуйн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийн болон чанарыг энэхүү тушаалын холбогдох заалтуудад нийцүүлэн дүгнэж, жил бүр байгууллагын удирдлага болон холбогдох байгууллагад гаргаж мэдээлж байна.
3. Сувилахуйн албадын үндсэн үүрэг нь сувилагчдын сувилах арга барил, ур чадварыг нэмэгдүүлэх асуудал бөгөөд онош тавих түүний дагуу хийх ажлын төлөвлөгөө боловсруулалт, хэрэгжүүлсэн, дүгнэсэн байдлын үнэн магадлалыг тасаг, нэгж, байгууллагын хүрээнд хэлэлцүүлэн, санал авч, дүгнэлт гарган үйл ажиллагааг байнга сайжруулж ажиллана.

СЭМҮТ-ийн Ерөнхий захирлын
2016 оны сарын ...-ны өдрийн
.... дугаар тушаалын дүгээр хавсралт

Шаардлагатай үйлчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх заавар

/Маржори Гордоны үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдлыг үйл ажиллагааны 11 хэв шинжээр үнэлэх буюу сувилагч, сувилгааны үйл ажиллааны үнэлгээ өгөх үе шатыг хэрэгжүүлэх нь/

Ерөнхий зүйл:

1. Шаардлагатай үйлчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэхдээ Эрүүл мэндийн сайдын 450 дугаар тушаалаар батлагдсан “Сувилагч, эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх хуудас”-ын дагуу үнэлнэ.
2. Тухайн үйлчлүүлэгчид илүү нарийвчилсан үнэлгээг хийх шаардлагтай гэж үзсэн тохиолдолд Гордоны үйл ажиллагааны 11 хэв шинжийн үнэлгээний аргыг хэрэглэх буюу үнэлгээний аль нэг хэсгийг нэмэлтээр ашиглаж болно.
3. Энэхүү үнэлгээний аргыг шинэ төгссөн сувилагчийг дадлагажуулах болон нийт сувилагчдын үйлчлүүлэгчийн биеийн байдалд үнэлгээ өгөх арга барил, ур чадварыг сайжруулах сургалтанд хэрэглэнэ.

№	Үйлчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх зорилго ангилал	Сувилагчийн үнэлэх зүйл, үйл ажиллагаа	
	Сувилагчийн үнэлэх зүйлс, сувилгааны оношийн тэмдэглэл	Мэдээлэл цуглуулах арга	<ul style="list-style-type: none"> - Бодит бус мэдээлэл (ббм) – үйлчлүүлэгчийн өгүүлэмж, асуумж - Бодит мэдээлэл (бм) – бодит үзлэг, ажиглалт, шинжилгээний дүн
1.	<p>Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдал</p> <p>Үйлчлүүлэгчийн биеийн ерөнхий байдлын тухай мэдээлэл цуглуулах ба амьдран буй орчин нөхцөл дэх бодит байдлаас үүдэлтэй эрсдэлт хүчин зүйлс цаашид авах арга хэмжээг тодорхойлно.</p>	<ul style="list-style-type: none"> - Үйлчлүүлэгчийн биеийн ерөнхий байдал, хэв шинж, эрүүл мэнд, оршин буй амьдралын хэв маяг, амьдран буй нөхцөл /гэр, байшин/, орлого, санхүүгийн байдал - Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалт, анхан шатны тусламжид хамрагдалт - Эмнэлэгт өмнө нь эмчлүүлж байсан түүх, гэр бүлийн эрүүл мэндийн байдлын түүх, мэс засал болон бусад ажилбар хийлгэсэн байдал, эмчилгээний түүх - Эмчийн заалтаар болон 	<p>(ббм):</p> <p>Үйлчлүүлэгч эрүүл мэндийнхээ асуудлаар ярьж буй өгүүлэмж, асуумж, амьдарч буй орчин нөхцөл</p> <p>(бм): Биеийн ерөнхий бодит үзлэг, амин үзүүлэлт, цусны даралт, өндөр, жин, гадаад үзэмж, хувцаслалт, үс</p>

		<p>заалтгүй хэрэглэж ирсэн эмийн нэр, тун, хэмжээ</p> <ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлс, эрүүл мэндэд хортой дадал зуршил /тамхи татах, архи тамхины хэрэглээ/ 	<p>засалт, үзэл бодлын илэрхийлэл</p>
2.	Үйлчлүүлэгчийн хоол тэжээл ба бодисын солилцооны байдал		
	<p>Хоол ба шингэний хэрэглээ бодисын солилцооны хэрэглээ</p> <p>Хоол тэжээл болон бодисын солилцооны хэвийн хэмжээтэй харьцуулсан дүгнэлт</p> <p>Шингэний тэнцэл, эд эсийн бүрэн бүтэн байдал, биеийн дархлаатай холбоотой бодит болон болзошгүй асуудлууд, хоол тэжээлийн замын хэвийн болон хэвийн бус үйл ажиллагааг тодорхойлох</p>	<ul style="list-style-type: none"> - Өдөрт иддэг хоол, зуушны давтамж - Хоолны төрөл ба хэмжээ - Сүүлийн 3 өдрийн ба 24 цагийн хоол хүнсний хэрэглээ - Ихэвчлэн цуглуулдаг хүнсний бүтээгдэхүүн болон хоол бэлтгэдэг зуршил - Үйлчлүүлэгч өөрийн биеийн асуудлаарх сэтгэгдэл - Хүнсний хэрэглээнд шашны болон тухайн бүлэг хүн амын соёл, ёс заншлын шинжтэй хоол зонхилдог эсэх - Бодисын солилцооныхоо байдлаар, түүний сэтгэгдэл, хэрэгцээ, мэдлэг, мэдээлэл - Холбогдох нөлөөлөл үйл ажиллагаа, өвчлөл, бухимдал - Залгиурын байдал, хоолны дуршил, амт, үнэр, мэдрэх байдал, шүдний эрүүл мэнд, амны хөндийн салстын байдал, дотор эвгүй оргих, бөөлжилт, хоолны дэглэм, хориглодог зүйлс, хүнсний зүйлийн харшил 	<p>(ббм):Хоол шингэний дадал, зуршлын талаар өгүүлэмж, асуумж</p> <p>(бм): Бодит үзлэг, арьс салстын байдал, хэвлийн хэмжээ, мэдрэл сэтгэцийн үзлэг, арьс, үс, хумс, хэвлийн байдал, биеийн жингийн индекс ба алдагдал, шинжилгээний дүн</p>

3.	<p>Ялгаруулах үйл ажиллагаа</p> <p>Гэдэс хэвлий давсагны үйл ажиллагаанд үнэлгээ өгөх, (шээс задгайрал, өтгөн хаталт, суулгалт, хэвийн бус байдал)эрсдлийг тодорхойлох</p>	<ul style="list-style-type: none"> - Шээс ялгаруулалт: давтамж, хэмжээ, өнгө, үнэр, шөнийн шээс, хянах чадвар, бусад өөрчлөлт - Өтгөн гадагшлуулалт: давтамж, өнгө, хэмжээ, бүтэц, хатсан болон суулгалт, хяналттай бусад өөрчлөлт - Өөртөө асаргаа хийх чадвар: бие засах, ариун цэвэр сахих явц, чадвар - Ялгаруулах үйл ажиллагаанд нэмэлт тусламж, эм хэрэглэдэг гуурс болон бургуй ашигладаг - Давсагны үрэвсэл, түүнээс сэргийлдэг зуршил - Холбогдох биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн байдал 	<p>(ббм): Өтгөн шингэний байдал, түүний гадагшлуулалт, зуршил, хяналт тавих чадварын талаар өгүүлэмж, асуумж</p> <p>(бм): Холбогдох биеийн бодит үзлэг, хэвлий, бэлэг эрхтэн, түрүү булчирхай, арьс, шулуун гэдэсний үзлэг, шинжилгээний дүн</p>
4.	<p>Биеийн дасгал хөдөлгөөн, идэвхитэй байдал</p> <p>Биеийн тамир, дасгал, хөдөлгөөн хийдэг эсэх, хөдөлгөөний идэвхийг тодорхойлох</p>	<ul style="list-style-type: none"> - Өдөр тутмын амьдралын /хөдөлгөөний/ хэвшил - Дасгал хөдөлгөөн: хэлбэр, давтамж, үргэлжлэх хугацаа, эрчим - Чөлөөт үйл ажиллагаа - Дасгал хөдөлгөөний талаарх ойлголт, сэтгэгдэл, туршлага - Өөртөө анхаарал тавих чадвар: хувцсаа өөрөө өмсөх 	<p>(ббм): Амьдралын өдөр тутмын үйл ажиллагаа, цагийн хуваарь, энерги, зарцуулалтын талаарх өгүүлэмж, асуумж</p> <p>(бм): Амьсгал, зүрх судасны</p>

		<p>тайлах, солих бүрэн чадвартай эсэх</p> <ul style="list-style-type: none"> - Усанд орох, бие засах, хооллоход биеэ бүрэн даасан, бусдын тусламж хэрэгтэй болон хараат - Хэрэглэдэг аппаратууд: таяг, тулгуур, тэрэг, тэргэнцэр - Холбогдох биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн байдал 	<p>үзлэг, захын судасны үзлэг болон цээж булчингийн бодит үзлэг, булчин, үе, мөч, хөдөлгөөн, хүчдэл, идэвх</p>
5.	<p>Нойр ба амралт</p> <p>Үйлчлүүлэгчийн унтаж амрах, алжаал тайлах, бодит байдлыг үнэлснээр мэдрэл сэтгэхүйн, амралт, ажлын зохицуулалтын байдалд тулгуурласан хэв шинжийг тодорхойлох</p>	<ul style="list-style-type: none"> - Унтаж амрах дадал, зуршил, унтаж сэрдэг цаг хугацаа, унтаж амардаг орчин, унтаж сэрсний дараа бие амарсан байдаг эсэх - Соёлын заншил - Төлөвлөгөөт амралт, чөлөөт цагийн зохицуулалт, - Унтахдаа нэмэлт нойрны эм уух, ном унших, телевиз үзэх, тайвшруулах бусад аргууд хэрэглэж байж унтдаг эсэх, гүн нойрсох хүртэлх үргэлжлэх хугацаа - Унтаж байхдаа ярьдаг, шүдээ хавирдаг, тайван биш байдаг эсэх - Холбогдох хүчин зүйлийг судлах: өвдөлт, халууралт, насжилт, - Холбогдох биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн байдал 	<p>(ббм): Унтах, амрах, дадал зуршлын талаар өгүүлэмж, асуумж</p> <p>(бм): Гадаад төрх байдал, анхаарал татах байдал</p>

6.	Ойлголт, танин мэдэхүй, мэдрэмж		
Мэдээллийг ойлгож, ашиглах чадвар болон мэдрэхүйн байдлыг тодорхойлох	<ul style="list-style-type: none"> - Харах, сонсох, амтлах, хүртэх, үнэрлэх, мэдрэхүйн байдал - Мэдрэхүйд нөлөөлөх нэмэлт хэрэгсэл: Нүдний шил, сонсголын аппарат, бусад - Мэдрэхүйд сүүлийн үед гарсан өөрчлөлтүүд - Тав тух ба өвдөлтийн мэдрэмж - Өвдөлттэй холбоотой соёлын итгэл үнэмшил - Боловсролын түвшин - Шийдвэр гаргах чадварын байдал /эргэлзсэн, тээнэгэлзсэн, толгой эргэх, бадайрах шинж тэмдгүүд/ - Холбогдох биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн байдал 	<p>Энэ хэсгийг мэдрэхүйн (5 мэдрэхүй) ба ойлголтын (мэдлэг, мэдээллийн түвшин, хэл яриа) байдал гэсэн 2 бүлэгт хувааж үнэлнэ.</p> <p><u>А. Мэдрэхүйн байдал:</u></p> <p>(ббм): Гэрэл, өнгө, өвдөлт, доргио, хөдөлгөөнийг мэдэрч байгаа байдлаар нь үнэлнэ.</p> <p>(бм): Хараа шалгах, сонсгол шалгах, өвдөлт мэдрэх байдал, гавал тархины мэдрэхүйн үзлэг, амт, үнэр, хүрэн мэдрэхүйн үзлэг хийнэ.</p> <p>Б.Ойлголтын байдал:</p>	

			<p>ббм): Мэдээллийн хүлээн авах, ойлгох, шийдвэр гаргах үйл явц</p> <p>(бм): Оюун санааны байдал үнэлэх үзлэг, бодит үзлэг</p>
7.	Хувь хүн, хувь хүний үзэл баримтлал		
	Хувь хүний дүр төрх, үйлдэл, үзэл баримтлалыг тодруулах	<ul style="list-style-type: none"> - Нийгэмшил: Ажил эрхлэлт, гэр бүлийн байдал, нийгмийн гарал - Хувь хүний илэрхийлэл: өөрийнхөө тухай хувь хүний илэрхийлэл, давуу болон сул тал - Биеийн илэрхийлэл: Бие махбодидоо санаа зовж явдаг болон дуртай дургүй талаар илэрхийлэл - Үүргийн илэрхийлэл: Өвчлөл болон бусад зүйлсээс болж эрх үүргийн өөрчлөлт, зовиол - Холбогдох, биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн байдал 	<p>(ббм): Өөрийгөө үнэлэх үнэлэмж, хувийн онцлог, сэтгэлзүйн байдлын талаар өгүүлэмж, асуумж</p> <p>(бм): Биеийн хэл, илэрхийлэл, хөдөлгөөн, нүдний контакт, дуу, хэл ярианы хэв маяг, сэтгэл хөдлөл, сэтгэл санааны болон бодлын агуулга</p>
8.	Үүрэг харилцааны хэв шинж		
	Үйлчлүүлэгч амьдран буй орчиндоо хүлээдэг үүрэг болон харилцаа	<ul style="list-style-type: none"> - Гэр бүл, найзууд, хамтран амьдрагч, хамт ажиллагсадтайгаа харилцах харилцаа, сэтгэл ханамж - Эрүүл мэнд нь харилцаанд нь 	<p>(ббм): Гэр бүл, ажил, нийгэмд гүйцэтгэх үүрэг, сэтгэл ханамжийн байдал, өгүүлэмж,</p>

	холбоондоо сэтгэл ханамжтай эсэх	<p>нөлөөлдөг эсэх</p> <ul style="list-style-type: none"> - Гэр бүлийн бүтэц, ба дэмжлэг - Гэр бүлийн гишүүдийн шийдвэр гаргалт - Хүүхэд гэр бүлд тулгамдаж буй асуудал, санаа зовинол - Өвөрмөц үүрэг хүлээдэг эсэх - Холбогдох, биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн байдал 	<p>асуумж</p> <p>(бм): Ойр дотныхон болон нийгмийн бүлэгтэй харилцах байдал, гэр бүлийн удам угсаа</p>
9.	Бэлгийн болон нөхөн үржихүйн байдал		
	Бэлгийн амьдрал хэв маяг, сонирхол, дадал, нөхөн үржихүйн байдал, үйл ажиллагаа, сэтгэл ханамжийн хэв шинжийг тодруулах, авах арга хэмжээг төлөвлөх	<ul style="list-style-type: none"> - Бэлгийн харилцааны талаарх сэтгэл зовинол, асуудал - Бэлгийн харилцааны тогтсон зан үйл, аюулгүй бэлгийн харилцаа - Нөхөн үржихүйн болон бэлгийн харилцааны талаарх ойлголт - Эрүүл мэндийн байдлаас болсон нөлөө бий эсэх - Өгүүлэмжтэй холбоотой биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн байдал, үзлэг 	<p>ббм): Бэлгийн харилцааны чиг баримжаа, түүх, үйл ажиллагаа, харилцаа холбоо, сэтгэл ханамжийн түвшингийн илэрхийлэл</p> <p>(бм): Эрэгтэй эмэгтэй бэлэг эрхтэний үзлэг, хөхний үзлэг</p>
10.	Асуудлыг даван туулах, дасан зохицох чадвар		
	Бухимдал, асуудлыг даван туулах чадварыг дэмжих	<ul style="list-style-type: none"> - Бухимдлын байдал, үүсгэж буй нөхцөл байдлыг тодруулах - Бухимдлыг хүлээн авч буй байдал - Бухимдалд хариу үзүүлж буй нийтлэг болсон өвөрмөц дүр төрх - Амьдралд сүүлийн үед гарсан 	<p>ббм): Амьдралд тулгарсан бухимдал, даван туулах, зохицох чадвар, ойлголтын талаар өгүүлэмж, асуумж</p> <p>(бм): Зан төрх,</p>

		<p>гол өөрчлөлтүүд, уй гашуу</p> <ul style="list-style-type: none"> - Бухимдал тайлдаг арга, үзүүлж буй үр дүн - Биеэ барих, чиглүүлэх чадамж - Стресс менежментийн тухай мэдлэг, арга техник - Стресс менежментийг гэр бүлийн гүшүүдэд хэрэглэдэг эсэх - Бие сэтгэцийн үзлэг 	<p>бодол, үйл ажиллагааны талаар бодит мэдээ, материал цуглуулах</p>
11.	<p>Үнэт зүйл, итгэл үнэмшил</p> <p>Тухайн хүний үнэт зүйлс, итгэл үнэмшил дээр тулгуурласан эсвэл түүний сонголт хийх, шийдвэр гаргаж, удирдан чиглүүлэх чадварт суурилсан дэмжлэг үзүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Соёл болон үндэс угсаа - Эрүүл мэндийн төрх байдал нь шашны болон үндэс угсааны ёс зүй, соёлтой нягт холбоотой эсэх - Санхүүгийн байдал - Амьдралын зорилго - Үнэт зүйлс - Шашин шүтлэг ба итгэл үнэмшил, гүйцэтгэдэг ёс заншил 	<p>ббм): Сайн муу, зөв үйл, буруу үйл гэж бодож явдаг үзэл бодол, итгэл үнэмшил, үнэт зүйлс, шийдвэр гаргахад нь нөлөөлдөг зүйлс</p> <p>(бм): Шашин шүтлэг, шашины итгэл үнэмшил, түүнд оролцох тогтмол үйл ажиллагаатай эсэх</p>

**Сувилахуйн тусламж үйлчилгээнд нэмэлтээр хэрэглэх
зарим онош, тодорхойлолт**

Ерөнхий зүйлс:

1. Сувилахуйн оношийг олон улсын хэмжээнд сувилахуйн онош батлан гаргах эрх бүхий “NANDA-1” байгууллагаас гаргасан 13 бүлгээс ангилах бөгөөд энэ бүлэгт ангилагдсан онош, түүний тодорхойлолтыг тусламж үйлчилгээнд байнга шинэчлэн, нэмэлтээр хэрэгжүүлж байна.
2. Сувилахуйн түүхийн “Эмчлүүлэгчийн биеийн байдлыг сувилагч, үнэлэх хуудас”-ын сувилахуйн асуудал буюу сувилгааны оношийг тавихдаа эдгээр оношийг нэмэлтээр тавьж болно.
3. Мөн түүнчлэн шинэ төгссөн сувилагчдыг дадлагажуулах болон, нийт сувилагчдын сувилахуйн онош тавих арга барил, ур чадварыг сайжруулах сургалтанд хэрэглэнэ.

№		Сувилгааны оношийн бүлэг	Онош	Тодорхойлолт
1.	1.	Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийг дэмжих	# Мэдлэг дутмаг	Үйлчлүүлэгч өөрийн эрүүл мэндэд үүссэн тодорхой нөхцөл байдлын талаар мэдлэг, дутмаг байх
	2.		# Эрүүл мэндийн зохицуулалт алдагдсан	Эрүүл мэндийн асуудлаа зохицуулах чадваргүй эсвэл асуудлаа хэрхэн зохицуулан зохион байгуулахаа мэдэхгүй болсноос сэтгэл гутрах, итгэл үнэмшлээ алдах, айх, эмчилгээний дэглэм сахих мэдлэг дутагдсанаас эдгэрэхгүй юм байна гэж бодож, эрүүл мэнд нь сайжрахгүй байх
2.	3.	Хоол тэжээл	# Залгих чадвар	Ам залгиур хоолой, улаан хоолойн бүтэц

			буурсан	үйл ажиллагааны алдагдалтай холбоотой хэвийн бус үйл ажиллагаа
	4.		# Бөглөрөх эрсдэл үүссэн	Гуурсан хоолойн замд гадны биет орж, бөглөрөл үүсгэх /шүүрлээс үүссэн шингэн бусад шингэн/
	5.		# Хоол тэжээлийн тэнцвэр алдсан /биед шаардлагатай хэмжээнээс багадах/	Хоол хүнсний тэжээллэг зүйлс бодисын солилцооны хэрэгцээг хангахгүй байх
	6.		# Хоол тэжээлийн тэнцвэр алдагдсан /биед шаардлагатай хэмжээнээс ихдэх/	Бодисын солилцооны хэрэгцээг ихэсгэх эрсдэлтэй хоол хүнсийг хэтрүүлэн хэрэглэх зуршил
	7.		# Огиудас хүрсэн шинжтэй	Дотор муухайрч бөөлжмөөр санагдах
	8.		# Элэгний үйл ажиллагаа алдагдсан	Элэгний үйл ажиллагаа алдагдах эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх эрсдэл үүсгэх
	9.		# Шингэн дутал	Шингэн багассан шинж тэмдэг, хуурайшилт, усаа алдах
	10.		# Шингэний хэмжээ ихэссэн	Изотоник шингэн биед ихээр хуримтлагдах
3.	11.	Ялгаруулалт	# Шээс задгайрсан	Хяналтгүйгээр шээс задгайрах
	12.	/бодисын солилцоо/	# Шээс ихээр хуримтлагдсан	Давсагаа бүрэн суллаж чадахгүй байх
	13.		# Шээс ялгаруулалт саатсан	Шээс ялгаруулалт сааталтай, чадахгүй байх
	14.		# Өтгөн хатсан	Өтгөн гадагшлуулахад хүндрэлтэй бүрэн хүндэрч чадахгүй байх, өтгөн хатах, давтамж цөөрсөн
	15.		# Суулгалт	Өтгөний агууламж өөрчлөлттэй, өтгөн шингэрсэн
	16.		# Амьсгалах хэв	Цусыг хангалтгүй хэмжээнд

			маяг өөрчлөгдсөн	хүчилтөрөгчөөр хангаж чадахгүй байгаа амьсгал авалт эсвэл амьсгал гаргалт
	17.		# Амьсгалын замын цэвэршилт алдагдах	Амьсгалын замын шүүрэл эсвэл саад болж буй зүйлийг гаргаж чадаагүйгээс амьсгалахад саадтай байх
	18.		# Агаарын солилцоо алдагдсан	Цулцан хялгасан судасны мембранд хүчилтөрөгч нүүрстөрөгч хэт ихсэх эсвэл багасах
	19.		# Цусны эргэлт алдагдсан /зүрхний, тархины, захын судасны, бөөрний/	Цусны эргэлт алдагдсанаас эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх
	20.		# Шокын эрсдэлтэй	Хялгасан судасны цус хангалтгүй болсноор эсийн амьдрах чадварыг бууруулах эрсдэл
4.	21.	Идэвхитэй байдал /амралт/	# Ядрах /ядаргаа/	Уцаар төрөх байнга ядарсан мэдрэмжтэй байх, оюуны ажил хийх чадвар нь хэвийн хэмжээнээс буурсан
	22.		# Биеийн хөдөлгөөн алдагдсан	Чөлөөтэй хөдлөх үйл ажиллагаа хийхэд бие махбодь сэтгэл зүйн хүч чадал хангалтгүй байх
	23.		# Алхах чадвар алдагдсан	Хөл дээрээ зогсох (эсвэл хиймэл мөч) бие даан хийх үйлдэл нь хязгаарлагдсан
	24.		# Хөдөлгөөн хязгаарлагдмал	Биеийн болон мөчдийн хөлөлгөөн алдагдах (орноос босч суух, шилжих, хөдөлгөөн, тэргэнцэр хэрэглэх)
	25.		# Өөрийгөө асрах чадваргүй болсон	Хооллох, хувцаслах, бие засах чадвар буурсан
	26.		# Нойргүйдэл	Нойронд муу болох гүн нойрсч амарч чадахгүй байх, нойр хулжилт
5.	27.	Ойлголт /танин мэдэхүй	# Будилуу болсон (цочмог, архаг)	Цочмог: түр хугацаанд ухаан санаагаа төвлөрүүлэх чадваргүй болох, (эргэж, сэргэх)

				Архаг: танин мэдэх чадвар эргэж сэргэхгүй, эсвэл урт хугацаанд эргэн сэргэх, зөнөх
	28.		# Ой санамж муудсан	Асуудал үйл ажиллагаагаа эргэн санахгүй байх
	29.		# Ярих чадвар сааталтай	Мэдээллийг хэл яриагаар бүрэн төгс илэрхийлэх чадвар буурсан
	30.		# Дасан зохицох чадвар буурсан	Гавлын дотоод даралтын тогтворгүй байдлаас асуудлыг давах туулах чадвар буурсан, тэнэгрэл
6.	31.	Хувь хүний үзэл баримтлал	# Итгэл алдарсан	Өөртөө итгэлтэй болж ямар нэгэн юманд сонголт хийх, шийдвэр гаргах чадваргүй болох, цөхөрсөн
	32.		# Өөрийгөө сэргөөр үнэлсэн (хурц, архаг)	Өөрийгөө үгүйсгэх хэт доогуур үнэлэх, сэргөөр харах байдал үүссэн (хурц-хэсэгхэн хугацаанд, архаг-удаан хугацаагаар үргэлжилж байгаа)
	33.		# Өөрийгөө үнэлэх бодит үнэлэмж алдагдсан	Өөрийнхөө үйлдэл, үйл ажиллагааг хянах чадваргүй болох
	34.		# Өөрийн дүр төрхдөө сэтгэл ханамжгүй болсон	Өөрийнхөө гадаад байдал дүр төрх, чадамжийг сэтгэлдээ доогуур үнэлэх, гутрах мэдрэмтгий байх
	35.		# Ганцаардах эрсдэлтэй	Бусадтай харилцахаас зайлсхийх мэдрэмж давамгайлсан
	36.		# Нийгмээс тусгаарлагдмал	Ганцаардах сэтгэгдэлтэй, бусдын зүгээс дарамт, шахалт ихтэй, айсан байдалтай
9.	37.	Хүндрэл бэрхшээлийг даван туулах чадвар	# Бухимдалтай	Дотоод эсвэл гадаад бухимдал үүсгэгчийг бодитоор үнэлэж чадахгүй байх
	38.		# Тулгамдсан асуудлыг даван туулах хүсэл эрмэлзлэлтэй	Тулгамдсан асуудлыг зөвөөр ойлгож, даван туулах хүсэл, эрмэлзлэлтэй байх

	39.		# Сэтгэл түгшилтэй	Санаа зовнил ихтэй байх бодит ба бодит бус байдалд
	40.		# Айдастай	Аюул, заналаас болсон айдас, түгшүүр ихтэй байх
	41.		# Хүч тамиргүйдсэн	Бие сэтгэлийн хувьд цөхөрсөн байдалтай, асуудлыг шийдвэрлэхэд бухимдал үүссэн
10.	42.	Амьдралын зарчим	# Зан төлөв өөрчлөгдсөн	Өөрийн сонгосон ёс зүйн үйлдэл, зан үйлээ зохицуулах чадваргүй болсноос гарсан хариу үйлдэл
	43.		# Оюун санааны хэвийн байдал алдагдсан	Амьдралынхаа утга учир, зорилгоо тодорхойлох нэгтгэх чадвар алдагдсан
11.	44.	Аюулгүй байдал	# Халдварын эрсдэлтэй	Халдварт өртөх эрсдэлтэй
	45.		# Бохирдох эрсдэл	Эрүүл мэндэд хор хөнөөл учруулахуйц хэмжээгээр хүрээлэн буй орчны бохирдол эрүүл мэндэд нь нөлөөлөх эрсдэл өндөртэй нөхцөл байдалтай
	46.		# Хортой нөхцлийн эрсдэлтэй	Хортой нөхцөлд ажилладаг, амьдралын нөхцөл, эмийн бодисын хордуулахуйц тун, хэмжээг хэтрүүлэн хэрэглэх, аюултай бүтээгдэхүүн биед санамсаргүй байдлаар нөлөөлөх эрсдэлтэй
	47.		# Харшлын эрсдэл өндөртэй	Хэт мэдрэг, хариу урвал
	48.		# Амьсгал боогдох эрсдэл өндөртэй	Санамсаргүй байдлаар амьсгал боогдох, багтраа, багтрах эрсдэл өндөртэй, (амьсгал авахад хангалттай хэмжээний агаар дутагдалтай)
	49.		# Цус алдах эрсдэлтэй	Цус багадалтаас үүсэх эрсдэл
	50.		# Мэс заслын шарх	Хагалгааны дараа хэвийн байдалдаа

			удаан эдгэрэлттэй	орох хугацаа уртассан
	51.		#Бэртэж гэмтэх эрсдэлтэй	Унах, бэртэх, биед гэмтэл учрах эрсдэл
	52.		# Халууралттай	Биеийн температур хэвийн хэмжээнээс их байх
	53.		# Биеийн халуун алдагдалтай	Биеийн температур хэвийн хэмжээнээс бага байх
	54.		# Хөлдөлт, # Түлэгдэлт	Халуун эсвэл хүйтэнтэй холбоотой шархдах
	55.		# Дулаан зохицуулга алдагдсан	Биеийн температур хэлбэлзлэлтэй байх
	56.		# Эд гэмтсэн	Салстын мембран, эвэрлэг бүрхүүл, бүрхүүлийн тогтолцоо эсвэл арьсан доорх эдийн гэмтэл
	57.		# Амны хөндийн салт гэмтсэн	Уруул болон амны хөндийн зөөлөн эдийн гэмтэл
	58.		# Арьс гэмтсэн	Арьсны давхаргууд гэмтэх
12.	59.	Тав тух	# Өвдөлттэй (цочмог, архаг)	Хурц өвдөлт: Тухайн хугацаанд тодорхойлогдох хэзээ дуусахыг нь тааварлаж эсвэл урьдчилан мэдэж болохуйц, 6 сараас доош мөн үргэлжлэх, багаас хүчтэй хүртэл өвдөлт мэдрэгдэх, гэнэт эсвэл аажим эхэлдэг таагүй мэдрэмж Архаг өвдөлт: Тухайн хугацаанд тодорхойлогдох хэзээ дуусахыг нь тааварлаж эсвэл урьдчилан мэдэж болохуйц, 6 сараас доош мөн үргэлжлэх, багаас хүчтэй өвдөлт хүртэл гэнэт эсвэл аажим эхэлдэг таагүй мэдрэмж
	60.		# Тав тух алдагдсан	Бие махбодь, сэтгэл санаа, сүсэг бишрэл, хүрээлэн буй орчин болон нийгмийн байдалдаа эрх чөлөөтэй,

				тайван болон сэтгэлдээ хүртэл байж чадахгүй байгаа мэдрэмжтэй үйлчлүүлэгч
--	--	--	--	---

Эх үүсвэр” Nursing diagnose”- 2012-2014 (2009 онд хуралдсан “NANDA-1”
байгууллагын 9 дүгээр хуралдаанаар нэмэлт өөрчлөлт оруулан баталсан)